



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/152

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагаын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсаны дагуу сумдын Засаг даргын Тамгын газарт олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, гэрээ байгуулан, хүлээн авахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй:

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323010117

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны  
 өдрийн 115 дугаар захирамжийн хавсралт



№	Төсөл арга хэмжээний нэрс	Нийт төсөвт өртөг	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын дарга
<b>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт</b>						
1	Сумын төвийн гудамж, зам талбайн тохижилт (Булган сум)	250,000.0	250,000.0	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
2	Холбооны замын уулзварын гэрлэн дохио (Булган сум)	80,000.0	80,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаяр
3	Гурванбулаг сумын ЗДТГ-ын барилгын засвар	50,000.0	50,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Гурванбулаг сумын Засаг дарга Б.Дэлгэр
4	Сумын төвийн зам засвар (Рашаант сум)	100,000.0	100,000.0	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Рашаант сумын Засаг дарга Б.Бат-Эрдэнэ
<b>НИЙТ ДҮН</b>		<b>480,000.0</b>	<b>480,000.0</b>			